



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 11 сарын 18 өдөр

Дугаар Б/113

Чингис хот

**Э.Заяасайханд буцалтгүй
тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын "Дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дэргэдэх Архивын тасгийн Цахим сангийн ажилтан Э.Заяасайханы гаргасан өргөдлийн дагуу нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 50,000 (тавин мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах 50000 (тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн (Ш.Эрдэнэжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР